



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/157

Булган сум

Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдэд иргэдэд зориулсан сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 204 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн байгаль орчныг хамгаалах талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах зорилгоор 2024 оны 03 дугаар сарын 15-наас 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд байгаль орчны тэмдэглэлт өдрүүдэд, иргэдэд зориулсан сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулсугай.

2. Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдэд, иргэдэд зориулсан сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр, ажлын төлөвлөгөөг 2 дугаар, зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдэд, иргэдэд зориулсан сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д тус тус үүрэг болгосугай.

4. Дээрх ажилд шаардлагатай 19,596,400 (арван есөн сая таван зуун ерэн зургаан мянга дөрвөн зуу) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдэд, иргэдэд зориулсан сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах” төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

8324010217

Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 15-ны өдрийн А/АСГ дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДЭД, ИРГЭДЭД ЗОРИУЛСАН
СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг.Зорилго:

Байгаль орчныг хайрлан хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах талаар иргэд олон нийтэд тодорхой мэдээлэл, мэдлэгийг олгож, хүн бүр байгаль хамгаалагч байх талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд энэхүү үйл ажиллагааны зорилго оршино.

Хоёр.Сургалт, сурталчилгааны арга хэлбэр:

Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай сурталчилгаа, постер, мэдээллийг байгууллагын пэйж хуудас болон олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлан таниулж, тэмдэглэлт өдрүүдээр байгаль орчныг хайрлан хамгаалах талаар сургалт сурталчилгаа, өдөрлөг, тэмцээн уралдаан зохион байгуулан иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.

Гурав.Хамрах хүрээ:

Булган сумын 6 багийн иргэд, тус суманд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагууд, сургуулийн болон сургуулийн өмнөх боловсролын байгууллага.

Дөрөв.Хэрэгжүүлэх хугацаа:

Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдэд иргэдэд зориулсан сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулна.

Тав.Сургалт сурталчилгаа хийх бүрэлдэхүүн :

- 1.БОАЖГ-ын мэргэжилтнүүд
- 2.Хануй голын сав газрын захиргааны мэргэжилтнүүд
- 3.УЦУОШТ-ийн холбогдох мэргэжилтэн
- 4.Булган сумын ЗДТГ, ТҮА холбогдох албан тушаалтнууд оролцоно.

Зургаа.Үр дүн:

Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг, тэмдэглэн өнгөрүүлснээр иргэд, олон нийтийг байгаль орчноо хайрлан хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, “Хүн бүр байгаль хамгаалагч мөн” гэсэн ойлголтыг эзэмшүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 13-ны өдрийн А.715/24 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДЭД, ИРГЭДЭД ЗОРИУЛСАН
СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Зардал (мян.төг)	Хариуцах мэргэжилтэн	Хамтран хэрэгжүүлэгч
1	2	3	4	5	6
1	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд “Уур, амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааны талаар аймгуудын БОАЖГ-ын албан хаагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулах	03.15- 5.17	14,850.0	Д.Нэмэхбаяр Г.Баяржаргал Ц.Ганчимэг Д.Энхнаран	Орхон аймгийн БОАЖГ
2	Эх дэлхийн цагийг тэмдэглэн өнгөрүүлэх	03.18- 03.30	2,216.4	М.Алтанцэцэг М.Хос-Эрдэнэ	Булган сумын ЗДТГ УЦУОШТ
3	Дэлхийн байгаль хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх	04.01- 04.15	1,680.0	Г.Баяржаргал Д.Нэмэхбаяр	Хануй голын сав газрын захиргаа
4	Мод тарих үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах	05.01- 5.12	850.0	Б.Отгонжаргал Н.Цасанчимэг Э.Очирбат	Ойн ангиуд, Сумдын ЗДТГ
	Нийт		19,596.4		

Аймгийн Засаг даргын 2024... оны
 03 дугаар сарын 13-ны өдрийн А/157 дугаар
 захирамжийн 3 дугаар хавсралт



Дэлхийн Ой, Ус, Цаг уур, Байгаль хамгаалах өдрийг угтаж "Уур, амьстгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааны талаар аймгуудын БОАЖГ-ын албан хаагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулах зардал

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ (төг)	Нийт (төг)	
1	2	3	4	5	6	
1	Байр (Анаг тур амралт)	Ор/хоног	65/3	55 000	10 725 000	
2	Заалны түрээсийн зардал	өдөр	1	100 000	100 000	
3	Хэвлэл	Хулдаас 4*6	м ²	48	15 000	720 000
		Медалийн бүч, бичвэр	ш	42	4000	168 000
4	Шүүгчийн зардал	хүн	4	110 000	440 000	
5	Тэмцээний медаль	Гар бөмбөг	ш	24	25 000	600 000
		Ширээний теннис	ш	6	24 500	147 000
		Дартс	ш	6	25 000	150 000
6	Шагнал	Гар бөмбөг	1 байр	1	400 000	400 000
		Гар бөмбөг	2 байр	1	300 000	300 000
		Гар бөмбөг	3 байр	1	200 000	200 000
		Ширээний теннис	1 байр	2	150 000	300 000
		Ширээний теннис	2 байр	2	100 000	200 000
		Ширээний теннис	3 байр	2	50 000	100 000
		Дартс	1 байр	2	150 000	150 000
		Дартс	2 байр	2	100 000	100 000
Дартс	3 байр	2	50 000	50 000		
Нийт					14 850 000	

Эх дэлхийн цагийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний зардал

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төг)	Нийт үнэ (төг)
1	2	3	4	5	6
1	Лаа	ш	250	1600	400 000
2	Open mic зохион байгуулах (Тайз, узель түрээс)	Өдөр	1	500 000	500 000
3	Тэмдэглэлт өдрүүдэд зориулсан хулдаасан хэвлэл	м ²	24	15 000	360 000
		ш	14	57 600	806 400
		ш	6	25 000	150 000
Нийт					2 216 400

**Дэлхийн байгаль хамгаалах, Байгаль орчны мэргэжилтнүүдийн
өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний зардал**

Д/д	Зардал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төг)	Нийт үнэ (төг)	
1	2	3	4	5	6	
1	Медаль	Гар бөмбөг	1 байр	8	15 000	120 000
		Гар бөмбөг	2 байр	8	15 000	120 000
		Гар бөмбөг	3 байр	8	15 000	120 000
2	Шагнал	Гар бөмбөг	1 байр	1	450 000	450 000
		Гар бөмбөг	2 байр	1	350 000	350 000
		Гар бөмбөг	3 байр	1	200 000	200 000
3	Шүүгчийн хөлс	хүн	2	110 000	220 000	
4	Заал түрээс	хүн	1	100 000	100 000	
Нийт					1 680 000	

Мод тарих үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах арга хэмжээний зардал

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төг)	Нийт үнэ (төг)
1	2	3	4	5	6
1	Хэвлэл (хулдаас)	м ²	24	15 000	360 000
2	Гадаа талбайд (узель түрээс)	Өдөр	1	300 000	300 000
3	Мод тарих зөвлөмж	ш	250	760	190 000
Нийт					850 000